

ХОВД АЙМГИЙН ЧАНДМАНЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Огноо: 2020 оны 05 сарын 21

БАТЛАВ:

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Б.ГАЛБАДРАХ

**ЧАНДМАНЬ СУМЫН ТӨВИЙН ГУДАМЖНЫ ГЭРЭЛТҮҮЛЭГ ТАВИХ АЖЛЫН ҮНИЙН
САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: ГУДАМЖНЫ ГЭРЭЛТҮҮЛЭГ ТАВИХ

Төслийн дугаар: ХОАОНӨГ/202001068

Тендер
шалгаруулалт /
гэрээний нэр:

Тендер
шалгаруулалт /
гэрээний дугаар:

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

[ХОВД АЙМГИЙН ЧАНДМАНЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР] нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **[ГЭРЭЛТҮҮЛЭГ ТАВИХ АЖИЛ]** гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **[2020 оны 05 сарын 29 өдрийн 14:00]**-аас өмнө **[<https://www.tender.gov.mn/>]** хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **[2020 оны 05 сарын 29]**-ны өдрийн **[14 цаг 30 минут]**-т нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх. /Тийм/

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно. www.tender.gov.mn

Ховд аймгийн Чандмань сумын Засаг даргын тамгын газар, санхүү албаны дарга С.Цэрэнханд-88434025, нягтлан бодогч Ү.Тунгалагбаяр- 88771721

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар,
2.1 ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**

4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.

4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.

4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.

4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын**

5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

**хүчинтэй
байх хугацаа**

- 6. Алдааг** 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг залруулах шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал** 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, болгосон тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн үнэ, түүнийг дагуу ирүүлнэ. үнэлэх
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ** 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх байгуулах эрх олгох утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ тухай мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн мэдэгдэл буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) мэдэгдэл тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ	
ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн [2018,2019] жилийн санхүүгийн тайлан</p> <ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн [2 жилийн] туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээ, хүлээж авсан актын хуулбар/; 2. Бусад нэмэлт шаардлага; Үнийн санал: Маягтаар ирүүлэх Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар батлуулсан хуулбар Нийгмийн даатгалын тодорхойлолт Харилцагч банкуудын хугацаа хэтэрсэн зээлтэй/үгүй эсэх тодорхойлолт Татварын өргүй эсэх тодорхойлолт <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: [шаардлагатай]</p> <ul style="list-style-type: none"> • БА-6,3 • БА-8,1 • Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар 15КВ <p>Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай. Үүнд: [тоног төхөөрөмжийг жагсаана]</p> <ol style="list-style-type: none"> 1. Авто шат буюу подъёмтой кран 2. Монтерын дөрөө 3. Цахилгаанчны багаж хэрэгсэл 4. Барилгын ажлын хэрэгсэл <p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: 2020 оны 05 сарын 29-ны өдрийн 14.00] –аас өмнө [https://www.tender.gov.mn] хаягаар ирүүлнэ /Улаанбаатрын цагаар/</p>
ТӨӨЗ 2.1	<p>Байгууллагын хаяг: [Ховд аймгийн Чандмань сумын Засаг Даргын тамгын газар]</p> <p>Давхар болон өрөөний дугаар: [1 давхар]</p> <p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: 2020 оны 05 сарын 29-ны өдрийн 14.30 минут</p>
ТӨӨЗ 2.1	<p>Байгууллагын хаяг: [Ховд аймгийн Чандмань сумын Засаг Даргын тамгын газар]</p> <p>Давхар болон өрөөний дугаар: Санхүүгийн өрөө</p>
ТӨӨЗ 2.3	<p>Долдугаар бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. [Тендерт оролцогчийг эрх бүхий болохыг нотлохтой]

	<p>холбоотойгоор ТШӨХ-д заасан бүх баримт бичгийг жагсаан бичих]</p> <ol style="list-style-type: none"> 2. ... 3.
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: [багцгүй]</p>

ДӨРӨВ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ:

1. Чандмань сумын Урд гол багийн 2-р хорьтод хийгдэх гудамжны гэрэлтүүлгийн ажил
2. Чандмань сумын Урд гол багийн 6-р хорьтын гэрэлтүүлгийн ажил
3. Сум руу орох хэсгийн гудамжны гэрэлтүүлэг
4. Албан байгууллагуудын гаднах талбайн эгц босоо гэрэлтүүлэг тавих

Нэр төрлийн дугаар	Бараа болон холбогдох үйлчилгээ	Техникийн тодорхойлолт болон стандарт
	<p>хаягжуулалт хийх ажил Зураг хар.</p>	<p>Урд гол багийн Жаргалант 6 дугаар гудамжны 600 тоотод байрлах хашааны доод булангаас хойшоо замын дээд талаар хойшоо Хойт гол 6 дугаар гудамжны 601 тоотод байрлах хашааны дээд тал хүртэл – 518,7 метр 14 ш гэрэлтүүлгийн шонгийн толгой нэмэх + 6 ш шонтой гэрэл шинээр суурилуулах, Тэгшээгийн 2 дугаар гудамжны хашааны зүүн хойд булангаас Тэгшээгийн 3 дугаар гудамжны зүүн урд булан хүртэл замын дээд хэсгийг дагасан шонгийн нэмэлт 6 ш гэрэлтүүлэг хийх – 300.3 метр 3ш шонтой гэрэл нэмэх, Эмнэлгийн зүүн урд булангаас урагшаа дунд голын гарам хүртэлх замын дээд хэсгийн шонтой гэрэлтүүлгийг нэмэх 6ш – 170 м зайд неон гэрэлтүүлгийг зурагт заасны дагуу хоорондоо 25-30 метрийн зайнд суулгаж, 150 ваттаас доошгүй чадалтай НЕОН гэрлүүдийг 5-6м, 2-2,5м- ийн өндөрт, махир, шулуун толгойнд бэхлэн суурилуулах ба гэрлийн тусгал нь доош чиглэсэн биш харагдах орчны талбайг их хамрахаар хийгдсэн байвал зохино.</p> <p>Шинээр баригдах ЗДТГ-ын үүдний ногоон байгууламж бүхий талбай, байгууллагууд, гудамж талбайн дээвэр, шон дээр 130 ш шар гэрлийг 2*2,5 мм-ийн голчтой утсаар цахилгаанд холбон бэхлэж тогтоох.</p> <p>Гэрэлтүүлгийн хийх, техникийн нөхцөл авахад гарах зардлыг гүйцэтгэгч бүлэг хариуцна.</p> <p>Гэрэлтүүлэг хийхдээ гэрэлтүүлгийн кабель, батарей, ламп тэжээл болон бусад төхөөрөмжийг чанарын өндөр түвшинд суурилуулах, шонгийн бэхэлгээг зуурмаг ашиглан сайтар хийж өгсөн байна. Гэрэлтүүлгийн төмөр шон нь үйлдвэрийн байна. Шонгийн суурь бэхэлгээг цементээр цутгалттай сууринд бэхэлж 4-6 боолтоор бэхэлж тогтоосон байна.</p> <p>Гэрэлтүүлэг хийгдэх нийт урт нь 2000 м-ээс доошгүй байх бөгөөд техникийн үзүүлэлт нь хавсралт 1 байна</p> <p>Ажил гүйцэтгэхэд шаардагдах бүх материал нь шинэ, ашиглалтын шаардлага хангасан байвал зохих ба гэрэлтүүлгийн ажлыг холбогдох дүрэм журмын дагуу мэргэжлийн түвшинд хийж гүйцэтгэх шаардлагатай.</p>

Өөрийн санаачилгаар хийсэн нэмэлт ажлууд давуу тал болно


Ажил гүйцэтгэх эцсийн хугацаа : 2020 оны 07 дугаар сар 01

Нийлүүлэх бараа, үйлчилгээний тоо хэмжээ, чанарын үзүүлэлт:

№	Захиалах бараа, ажил үйлчилгээ	Тоо ш	Чанарын үзүүлэлт	Тайлбар
1	Нарны зайн шонтой гэрэлтүүлэг	15	6 м өндөртэй шонтой, 150Вт-ын өөр дээрээ батерейтай, неон гэрэл	чанартай, аль ч улсад үйлдвэрлэсэн байж болно
2	нарны зайн шонгүй гэрэлтүүлэг	20	Зориулалтын болон зориулалтын бус шон дээр бэхлэх боломжтой, 150Вт неон гэрэлтэй, өөр дээрээ батерейтай, неон гэрэл	чанартай, аль ч улсад үйлдвэрлэсэн байж болно
3	Шар гэрэл	130	100 Вт-н 2*2.5 мм-ийн голчтой утсаар холбох	БНХАУ-д үйлдвэрлэсэн

Хавсралт1: Гэрэлтүүлгийн загвар, техникийн үзүүлэлт:

Загвар	~150 ваттаас доошгүй
Хүний мэдрэмж	Байж болно
Нарны хавтангийн чадал	18V200W
Нарны хавтангийн нас	25 жил
Нарны батарейн хэлбэр	Литиум батарей, бусад
Нарны батарейн баталгаа	5 жил
НЕОН дээд чадал	12V 18W
НЕОН гэрлийн брэнд	АНУ-ын Bridgelux брэнд
Люмен (LM)	2160-2340lm
НЕОН гэрлийн насжилт	50000 цаг
Гэрэлтэлтийн өнцөг	120 градус
Цэнэглэх хугацаа	6-7 цаг
Ажиллах хугацаа	20 цагаас илүү
Ажиллах температур (°C)	-20~+60
ССТ (к)	6500k-7000k
Шонгийн өндөр	6,5-6м
Гэрлийн шонгийн зай	20-25м
Их биений материал	Хөнгөн цагаан хайлш
Сертификат	ISO/CE / ROHS / IP65
Үйлдвэрийн баталгаа	1 жил
Гадна хэмжээ (мм)	920*325*43
Цэвэр жин	12кг
Хайрцагын хэмжээ (мм)	960*380*195
Хайрцаган дахь тоо шир	1 шир
Бохир жин	14.5 кг





Тав. ЗУРАГ

Зургийн санамж

Энд зургуудыг жагсааж бичнэ. Зураг, түүний дотор ажлын талбайн зургийг энэ бүлэгт, эсхүл тусад нь хавтсанд хийж хавсаргана.

Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж

Зорилт

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

(а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;

(б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарьт заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарьт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өртгийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарьт заавал оруулна.

Ажил-өдрийн хуваарь

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадалшгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

(а) тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.

(б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

Магадалшгүй зардал

Магадалшгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарьт заах замаар магадалшгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадалшгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарьт зааж болно. Магадалшгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно. Магадалшгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн) хэрхэн хэрэглэх аргыг заана. *Үе шатны ажлын хуваарь бэлтгэхэд зориулсан энэ санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно. Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулахгүй.*

Долоо. **ЖИШИГ МАЯГТ**

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг,

тамга: Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. **Гүйцэтгэгч** 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн ажил тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.
гүйцэтгэх
2. **Төслийн менежерийн шийдвэр** 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.
3. **Ажил дуусгах өдөр ажил дууссан байх** 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, дуусгах өдөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн төлөвлөсөн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, өдөр ажил ажил дуусгах өдөр дуусгана.
дууссан байх
4. **Аюулгүй байдал** 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.
5. **Зааварчилга а** 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй
6. **Маргааныг шийдвэрлэх** 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар хохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

7. **Ажлын хөтөлбөр** 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.
8. **Зөрчил** 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдол гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь илрүүлэх гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.
9. **Зөрчил, арилгах** 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын гологдол баталгаат хугацаа² дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд

² Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

- заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх** 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үе шатны ажлын хуваарь** 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх** 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги** 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон³ хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах** 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах** 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо** 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

³ Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
 - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
- (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
- (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
 - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг

гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ⁴

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <i>[Тендерийн урилгад заасан нэр болон дугаар]</i>
ГЕН 2.1	Ажил нь <i>[товч тодорхойлолт, түүний дотор төслийн хүрээнд бусад гэрээтэй холбогдох байдал]</i> -аас бүрдэнэ. Ажлын талбай нь <i>[байршил]</i> -д байрших ба зураг №...-д зааснаар тодорхойлогдсон болно.
ГЕН 3.1	Төслийн менежер нь <i>[томилогдсон этгээдийн нэр, хаяг]</i>
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр <i>[огноо]</i> Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <i>[огноо]</i> ⁵
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш <i>[тоо]</i> хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа <i>[тоо]</i> хоног байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <i>[хувь]</i> байна. ⁶ Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <i>[хувь]</i> байна.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг <i>[огноо]</i> -ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг <i>[огноо]</i> -ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ <i>[мөнгөн дүн]</i> байна.
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын <i>[хувь]</i> -р тооцно.

⁴ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

⁵ Ажлыг хэсэгчлэн дуусгахаар төлөвлөсөн бол эдгээр хугацааг жагсаана.

⁶ Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын _____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны ____ дугаар сарын _____-ны өдөр эхэлж, _____ оны ____ дугаар сарын _____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;

- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]